




"Соёл Эрдэм"

モンゴル文化教育大学



ХЭЛТЭЙ БОЛ ДАЛАВЧТАЙ

2023 он 6 сар

Улиралд нэг удаа


№ 65



ТӨГСӨЛТ
II НҮҮР



ГАДААД ХАРИЛЦАА
V НҮҮР



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ
VI НҮҮР

СОЁЛ ЭРДЭМ СУРГУУЛИЙН 24 ДЭХ УДААГИЙН
ТӨГСӨЛТИЙН БАЯР 2023 ОНЫ 5 САРЫН 23-НЫ ӨДӨР
БОЛЛОО. НИЙТ ТӨГСӨГЧДӨДӨӨ БАЯР ХҮРГЭЕ.

第24回卒業式が2023年5月23日に実施された
卒業生の皆さん、おめでとうございます



モンゴル文化教育大学附属高等学校が9月から開校

япон хэл,
мэдээлэл технологийн
гүнзгийрүүлсэн
сургалттай "СОЁЛ ЭРДЭМ"
АХЛАХ СУРГУУЛЬ 2023-2024
ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ЭЛСЭЛТЭЭ АВЧ ЭХЭЛЛЭЭ.
10, 11, 12 ДУГААР АНГИЙН
СУРАГЧДЫГ БҮРТГЭЖ
БАЙНА.

япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт

1. Сургалтын орчин ууний үнэмт тохиоромж бүхий сурч хөгжих талтай орчин
2. IT-компанийн лаборатори, япон, англи хэлний магистр анги, хими, биологийн лаборатори
3. Гүнзгийрүүлсэн сургалт япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт, сонгон суралцах хэрэгсэл, япон хэл, математик, физик, химийн лаборатори, япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт
4. Япон улсын ахлах сургуулийн хамтран суралцах хэрэгсэл, япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт
5. Япон улсын ахлах сургуулийн хамтран суралцах хэрэгсэл, япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт

УРИЛГА

Хамтран суралцах хэрэгсэл, япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт, сонгон суралцах хэрэгсэл, япон хэл, математик, физик, химийн лаборатори, япон хэл, IT-мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалт

О.Дуламсүрэн

Д.Алима

А.Очира

Н.Чулуунбат

Ц.Цэцэг

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА



Дээрх QR кодоор Соёл
Эрдэм дээд сургуульд
бүртгүүлнэ үү.



"Соёл Эрдэм" ахлах
сургуулийн 10, 11, 12
дугаар ангид дээрх QR
кодоор бүртгүүлнэ үү.



"Соёл Эрдэм"
дээд сургуулийн
танилцуулга

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Соёл Эрдэм дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцахаар хүсэлт гаргагч болон элсэлтийн ажиллагааг зохион байгуулах комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Боловсрол, Шинжлэх Ухааны яамнаас тухай бүр шинэчлэн гаргасан "Оюутан элсүүлэх журам"-д нийцүүлэн оюутан элсүүлнэ.
- 1.3. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг Соёл Эрдэм дээд сургуулийн элсэлтийн комисс удирдан зохион байгуулна.
- 1.4. Оюутан элсүүлэх бакалаврын хөтөлбөр болон харгалзах Элсэлтийн ерөнхий шалгалтын нэр

№	Хөтөлбөр	Хичээлийн нэрс	ЕШ-ын оноо	Хичээлийн нэрс	ЕШ-ын оноо
1	Гадаад хэлний орчуулга /Япон/ Нийгэм	Англи хэл Нийгэм	480	Математик Монгол хэл	480
2	Олон улс, орон судлал	Англи хэл Орос хэл	480	Нийгэм Түүх	480
3	Аялал жуулчлалын менежмент	Математик	440	Англи хэл Нийгэм	440
4	Программ хангамж	Математик Физик	480	Нийгэм Түүх	440

Хоёр. Элсэгчдэд тавигдах нийтлэг шаардлага

- 2.1. Бакалаврын өдрийн ангид элсэгч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна.
- 2.2. Элсэхийг хүсэгч нь бүлэгт заасан хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт /ЭЭШ/ өгч БШУЯ-аас баталсан үндэсний босго онооны болзлыг хангасан байна.
- 2.3. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан Монгол хэл бичгийн шалгалтыг өгсөн байна.
- 2.4. Эрүүл мэнд, сэтгэцийн хувьд тус сургуульд элсэхэд харшлах зүйлгүй байна.
- 2.5. СЭДС-д элсэхийг хүссэн гадаадын иргэний асуудлыг холбогдох журмаар шийдвэрлэнэ.

Гурав. Элсэгчийн бүртгэл

- 3.1 Болзол хангасан элсэгчийг Намрын улиралд тухайн хичээлийн жилийн ЭЭШ-ын дүн гарсан өдрөөс эхлэн тухайн оны 9 дугаар сарын 15-ны өдрийг дуустал Өвлийн улиралд элсэгчийг 2024 оны 1сарын 27-ны өдөр хүртэл СЭДС-ийн байранд бүртгэнэ.
- 3.2 Элсэгч дараах материалыг бүрдүүлсэн байна.

- Үүнд:
- Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж
 - Суралцагчийн хувийн хэрэг
 - Иргэний үнэмлэхний хуулбар
 - Суралцах эрхийн бичиг
 - Гараар бичсэн өргөдөл
 - 3*4 хэмжээтэй цээж зураг 6 хувь /сүүлийн 3 сарын дотор авахуулсан байх/
 - Бүртгэлийн хураамж /тухайн хичээлийн жилд захирлын тушаалаар батлаж мөрдөнө/
 - Сургалтын төлбөр төлсөн баримт (Зээл авах, төрөөс хариуцах бол холбогдох бичиг баримтууд, төрийн албаны тухай хуулийн дагуу төлөгдөх бол эцэг эхийн аль нэгний албан газартай хийсэн гэрээ).
 - Сургалтын төлбөрийг тухайн элсэлтийн жилдээ СЭДС-ийн Удирдах Зөвлөлөөр баталсан төлбөрийн дүнг баримтална.
 - Бүрэн дунд буюу түүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг гэрчилэх баримт бичиг зэрэг болно.
 - Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

モンゴル文化教育大学は「アマル財団」と覚書を締結した



Зургийн голд байгаа нь Монгол Улсын Их Хурлын гишүүн асан, Боловсрол, шинжлэх ухааны яамны сайд асан, мөн Монгол Улсаас АНУ-д суугаа бүрэн эрхт элчин сайд асан Ё.Отгонбаяр



左からアマル財団バトデルゲル代表、牧原理事長

Соёл Эрдэм дээд сургууль нь гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд "Мэргэн сайд Агданбуугийн Амар сан"-тай хамтран ажиллах санамж бичигт Соёл Эрдэм дээд сургуулийн удирдах зөвлөлийн дарга Макихара Соичи, "Мэргэн сайд Агданбуугийн Амар сан"-г төлөөлөн Тэргүүлэгч Ж.Батдэлгэр нар гарын үсэг зурлаа. Соёл Эрдэм дээд сургууль нь Япон улсын аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургуультай хамтран ажилладаг. Санамж бичгийн хүрээнд Орон нутгийн залуусыг Япон улсад интерншип буюу цалинтай дадлага хөтөлбөрт болон Япон улсад ур чадварын дадлагажигчаар явуулах тал дээр хамтран ажиллахаар болсон.

2023.05.18

モンゴル文化教育大学は「アマル財団」と地方の若者を技能実習生やインターンシップ生として日本へ送り出すための覚書を締結した。双方を代表してモンゴル文化教育大学の牧原創一理事長と「アマル財団」のJ.バトデルゲル代表が覚書に署名した。モンゴル文化教育大学は日本の大学・日本語学校及び企業との提携によって、在学生を日本でのインターンシップ等のプログラムに送り出しており、今回の覚書の締結によって、地方の若者がインターンシップ等のプログラムに参加する機会が拡大することとなった。

2023.05.18

2023 ОНД СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙГ ТӨГСӨЖ БАЙГАА 24 ДЭХ УДААГИЙН НИЙТ ТӨГСӨГЧИДДӨӨ ХОНХНЫ БАЯРЫН МЭНД ХҮРГЭЕ.

2023年度第24期卒業生の皆さんご卒業おめでとうございます。

Та бүхний суралцаж байх хугацаанд аюулт цар тахал “Шинэ корона вирус”-ын халдвар дэлхий нийтэд тархан жил гаруй танхимаар суралцах боломжгүй болж хичээлээ цахим хэлбэрээр судлахаас өөр аргагүй болж байсан билээ. Энэ нь багш оюутнууд аль алинд нь дасаж дадаагүй зүйл байж, та бүхэнд маш их төвөг учруулсан гэж бодож байна. Гэсэн ч энэ олон саад бэрхшээлийг даван туулж сургуулиа амжилттай төгсөж байгаад үнэхээр их баяртай байна. Дөрвөн жил хичээнгүйлэн суралцсан үүрнээсээ нисэн одох гэж буй та нарыгаа үдэж байгаадаа сэтгэлийн гүнд гуниг хурж байгаа ч бас маш их бахархаж байна.

Дээд сургууль төгсөнө гэдэг бол нийгмийн харилцаанд оролцож бие даасан хүн болно гэсэн үг юм. Та бүхнийг Соёл Эрдэм дээд сургуульд сурч эзэмшсэн япон хэлний мэдлэг чадвараа бүрэн дүүрэн ашиглаж амжилтанд хүрнэ гэдэгт итгэл төгс байна. Өмнөө тавьсан зорилго, баримтлах ёстой зарчмаасаа гажилгүй шамдан хичээгээрэй. Мөн хаана ч хэнийг ч үндэс угсаа, шашин шүтлэг, арьсны өнгөөр ялгалгүй харьцаж, даруу төлөв байж хүндэлж яваарай. Бусдыг хүндэлж харьцвал эргээд хүндлэл хүлээнэ. Та бүхний амьдралын ялалт, амжилтын анхны алхам бол итгэлдэл юм шүү. Энэхүү итгэлдэл нь амьдралын тань дэвжин дээшлэхийн эх үндэс болно гэдгийг битгий мартаарай.

Цаашид япон хэлийг түгээн дэлгэрүүлж, Япон Монгол хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гүүр болж, томоохон хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна. Та бүхэндээ амжилт хүсээд дахин чин сэтгэлийн халуун баяр хүргэе.



モンゴル文化教育大学
理事長 牧原創一

皆さんは、ここ4年間の在学中、地球全体の人類社会を襲ったコロナの渦に巻き込まれ、一年以上オンライン授業を受けざるを得なかったのです。それはまた、先生及び学生の皆さんにとっても不慣れなものでした。学生の皆さんには大変なご迷惑をかけたと思われます。しかし、こうした多くの困難を克服して卒業できたことは、嬉しい限りです。優秀な成績をもってモンゴル文化教育大学という巣を旅立つ皆様を見送るのは寂しい気持ちもありますが、誇りに思います。大学を卒業されることは、ある意味では、社会人としての自立だと言えます。皆さんが、モンゴル文化教育大学の利点である日本語教育を大いに生かして活躍されることでしょう。期待しています。

繰り返しになりますが、目的、理念を忘れずに、頑張ってください。また、どこであれ、だれであれ、民族、宗教、人種を問わず、謙虚な気持ちをもって相手を尊敬する精神は忘れずに頑張ってください。人を尊敬すれば相手にも尊敬されるのです。あなたたちの人生の勝利、その成功には第一歩として信頼信用が大いに求められるのです。信頼信用を失わずに頑張ってください。信頼信用は皆さんの躍進、人生を豊かにする源でもあります。

皆さんは、これから日本語教育を生かして、日本とモンゴルの親善交流の懸け橋として、大いに貢献するものだと確信しています。ご成功をお祈りします。最後になりますが、改めて心よりお祝い申し上げます。

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН 2022-2023 ОНЫ ЭРХЭМ ХҮНДЭТ ТӨГСӨГЧИД ӨӨ!

2023年度の卒業生の皆さんへ



モンゴル文化教育大学 学長
D. エルデネチメグ

Та бүхэн манай сургуулийн босгыг алхаж СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН оюутан хэмээн дуудуулж ирснээс хойш даруй 4 жил өнгөрчээ. Эрдэмд тэмүүлсэн дөрвөн жил харван өнгөрч, өнөөдрийн энэ өдрөөс эхлэн бид та нарыг манай сургуулийн ТӨГСӨГЧ гэж бахархалтайгаар дуудах боллоо. Оюутан насанд тохиолддог бүх сайхан учралууд шинэ найз нөхөд, шинэ мэдлэг, дурсамж дүүрэн баяр хөөртэй мөчүүд, аз жаргалтай өдрүүдийг дурсан явах боломжийг сургууль, багш нар нь Та бүхэнд олгосон гэж найдаж байна. Сургуулиа төгсчихсөн ч гэсэн цаашид төрөлх сургууль, багш нартайгаа үргэлж эргэх холбоотой байж, төгссөн сургуулийнхаа нэр төрийг өндөрт өргөж явна гэдэгт бид итгэж байна. Нандин мөрөөдлөө биелүүлэх амьдралын дараагийн алхамд чинь өндөр амжилт хүсэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг ерөөе!

モンゴル文化教育大学で4年間学び、今日が卒業式の日であります。勉強中心の4年間があつという間に過ぎて、今日から皆さんのことをモンゴル文化教育大学の卒業生と呼ぶことは何よりも誇りであります。学生時代の新しい友達、知識、たくさんの思い出と幸せな日々を過ごす機会を皆さんに与えることができてうれしく思います。

卒業してからも、大学や教職員と関わり続けてください。そして、モンゴル文化教育大学の卒業生として様々な分野で活躍してくれることを期待しています。

最後に、皆さんの健康、将来の成功を心からお祈りします。

ОЮУТАН АХУЙ ЦАГИЙН ДУРСАМЖ

学生時代の思い出

АМЬДРАЛЫН МИНЬ НЭГ ХЭСЭГ

Миний хувьд их сургууль гэдэг илүү нэг хүний амьдрал буюу бүх зүйлтэй ганцаараа нүүр тулах шинэ амьдрал хэмээн бодож явсан билээ. Соёл Эрдэм дээд сургуулийг сонгон элссэн нь одоо бодоход хамгийн зөв шийдвэр болсон юм.

Бусад их дээд сургуультай харьцуулахад хичээлийн байр нь авсаархан, оюутан нь ч цөөн, сонгох хичээл нь ч бага юм шиг санагдаж байсан нь саяхан мэт. Гэвч шинэ орчин, шинэ хүрээлэл, шинэ хэл сурч эхэлсэн нь өнөөгийн намайг өдий эзэртэй яваагийн эхлэл болсон юм. Анги хамт олны тогтолцоотой сургууль байсан учир хэдий шинэ хамт олон байсан ч нүд ирмэх зуур нэгэн гэр бүл шиг дотносож чадсан юм. Багш, сургуулийн удирдлагууд нь оюутнуудаа гэсэн сэтгэлтэй, сайхан хамт олны нэг хэсэг нь болж суралцсандаа өөрийгөө тун азтай гэж боддог.

Гуравдугаар курсэд сурч байхад үзэж судалсан япон хэлний мэдлэг минь надад Япон улсыг зорих хаалгыг нээж өгсөн юм. Гэр бүл найз нөхөд гээд бүгдийг нь орхиод явах болсон нь гунигтай байсан ч зорилго минь боломж болж ирсэнд маш их баярлаж билээ. Ингээд Японд гурван жил сурч хөдөлмөрлөн эргээд Монголдоо ирэхэд сургууль минь урьдын л адил Соёл Эрдэм сургуулийн оюутан хэвээр хүлээж авсанд үнэхээр их талархсан. Японд сурч байсан учир ангийнхантайгаа хамт төгсөж чадаагүй, нандин сайхан дурсамж бүтээх үеийг ч мөн өнгөрүүлчихсэн нь үнэхээр харамсалтай байсан. Гэсэн ч болоод өнгөрсөн зүйлийг залруулах боломжгүй учир цаашид надад ирэх гэж буй ирээдүйгээ тэсэн ядан хүлээж байна.

Эцэст нь хэлэхэд Соёл Эрдэм дээд сургуулийг үүсгэн байгуулагч болон багш нар хамт олондоо чин сэтгэлээсээ баярлалаа. Та бүхэнтэй өнгөрүүлсэн цаг хугацаа миний амьдралын минь томоохон нэг хэсэг мөнөөс мөн.

私にとって、大学と言うのは一人の道、すべてを自分で経験しなければならぬ新しい人生だと思っていました。モンゴル文化教育大学を選び、入学したことが最善の決断だったと思います。他の大学と比べると、学生数も授業数も少ない、小さな建物のように感じていたのが最近のことのようです。

しかし、新しい環境、新しいサークル、新しい言語を学ぶことが、現在の私への旅の始まりでした。クラス担任制なので、皆んなが気付いてないうちに家族のようになりました。生徒のことを気にかけてくれる素晴らしい先生達や学生などみんなを含めて、そのチームの一員になれたことをとても幸運に思っています。

3年生になって、今まで教えてもらった日本語が、私の日本に行くための扉を開いてくれました。家族や友人と離れるのは悲しかったですが、でも目標をつかむチャンスになったのは嬉しかったです。日本で3年間勉強し、働いた後、帰国したとき、大学が学生として、またモンゴル文化教育大学の一部として私を受け入れてくれて、とてもうれしく思いました。今さらですが、クラスメートと一緒に卒業できなかったのは残念ですし、大切な思い出を残すことができませんでした。が、過去は取り戻せないの、これからの未来が楽しみです。

最後に、モンゴル文化教育大学の先生達に心から感謝しております。みんなと過ごした時間は私の人生の大きな一部です。



4B анги Y.Тэргэл
日本語学科4年生 テルゲル

Оюутан насны сүүлийн жил нүд ирмэх зуур хурдан өнгөрчээ. Сүүлийн жил гэж бодоход гунигтай санагдаж байна. Сайхан дурсамж ч чамгүй олныг бүтээжээ. Эхний жилийн явган аяллаар ангийнхантайгаа танилцаж найз нөхөд болон маш хөгжилтэй байсан. Удалгүй сургуулийн сагсны тэмцээн болж охид хөвгүүдээрээ шилжин явах цомын эзэд болсон. Энэ нь ангиараа том амжилт үзүүлсэн анхны баярт мөч байсан гэж бодож байна. Өвөл нь сургуулийн Соёлын баяр болсон ба япон хэлээр ангиараа дуу дуулж тэргүүн байр эзэлсэн. Гэвч хэдэн сарын дараа Корона вирусийн халдвар тархаж сургууль соёл хаагдан хоёр жилийн хугацаанд онлайнгаар суралцсан учраас дурсамж нимгэн байна. Харин энэ жил буюу төгсөх жилээ манай ангийнхан нэгдэн нэгэн цул болж чадсан.

Оюутны дөрвөн жил сайн муу, баяртай гунигтай олон зүйлээр дүүрэн мартагдашгүй мөч байлаа.

学生時代の最後の一年はあつという間に過ぎていきます。昨年のことを思い出すと寂しいですが、良い思い出は少ないです。大学生になって初めてのハイキングに行ったとき、クラスメートと知り合いました。とても楽しかったです。それから、学校のバスケットボールの試合があり、クラスの女子学生チームと男子学生チームが優勝しました。1年生のときのその試合は学生時代が一番大きな成功になったと思います。冬は学校の文教祭で、クラスで初めて日本語で歌を歌い、優勝しました。しかし、数ヶ月後にコロナウイルスが流行して学校が閉鎖されたため、オンラインで2年間勉強したので、思い出はほとんどありませんでした。良いことも悪いこともありましたが、楽しくて、忘れられない4年間でした。

ХҮСЭЖ МӨРӨӨДСӨН ЗҮЙЛЭЭ ХИЙЖ ГҮЙЦЭЭСЭН НАНДИН ҮЕ МИНЬ




4B анги Б.Батгуяа
日本語学科4年生 パトマ

人生の大切な思い出の一つは確かに学生時代と思います。初めは長く感じていましたが、あつという間に過ぎた4年間でした。素晴らしい先生方に囲まれ、色々なことを学び、生涯の友ができた忘れられない思い出になりました。

世界中に広がったコロナウイルスの最中に勉強するのが大変でしたが、先生方が支えてくれたので、みんな一緒に頑張つて無事に終えました。そしてロックダウンされていた私たちもやっと会えることができて、また前のように一緒に文教祭の準備をしたり、遊んだりしていろいろなハッピーな思い出を作りました。3年生のときのことですが、ジョナサン先生と一緒に劇をしたり、スピーチコンテストで1位を取つたり、文教祭の司会をしたり、会話クラブを開いたりしていたなどは絶対忘れられないことです。

平凡な日々の中に小さな出来事があつて、幸せなことや不幸なこともたくさんあり、深い知識を得り、どう生きるべきなのかなどについて考えを深めた大変充実した素晴らしい4年間でした。いつも親切にサポートしてくれたモンゴル文化教育大学の教職員の皆さん、ずっと一緒に勉強して、お互いに手伝ってきたクラスメートたちに感謝しています。ご活躍お祈りいたします。



4B анги Б.Мөнхсүх
日本語学科4年生 ムンフスフ

ХҮСЭЖ МӨРӨӨДСӨН ЗҮЙЛЭЭ ХИЙЖ ГҮЙЦЭЭСЭН НАНДИН ҮЕ МИНЬ



4В анги М.Цөлмэг
日本語学科4年生 ツエルメグ

大学4年間は長いようであつという間だった。 私にとって大学時代とは何だったのだろうか。 まず、勉強の暗記であつた高校とは異なり、自分の興味関心と目標が必要になる大学では、本当の意味での「学び」、「知識」というものを教わつたように思う。そして対人関係。いい意味でも悪い意味でも刺激を受ける人たちとの出会いがあつた。その中で様々な価値観を持つ人たちと接し、交友を深めることは、私の中の視野や価値観を大きく広げてくれた。「大学生」とは思う存分、何でもやってみることができる貴重な時間であつたと思う。 後にも先にもこんな恵まれた身分はない。 失敗も後悔もたくさんあるが、それらも含めて自分を成長させてくれた大切な経験である。大学生活を楽しめたこと自体が、大変幸運であつたと思う。 充実したモンゴル文化教育大学での4年間に、そして私と出会ってくれた多くの人「ありがとう」と今、言いたい。

СУРГУУЛИА ТӨГСӨХ СҮҮЛИЙН ЖИЛ ЦЭРГИЙН АЛБАНД ЯВЖ ЭХ ОРНЫ ХҮҮ БОЛСОН



4В анги Н.Хаш-Эрдэнэ
日本語学科4年生 ハシエルデネ

高校を終えたばかりだったのは最近のような気がします。学生であることは、新しい感覚、新しい環境、新しい同僚、新しい先生… 私の人生で最も責任のある瞬間の 1 つです。私の家族は日本に住んでいるので、モンゴル文化教育大学で日本語を勉強することにしました。気づいたら大学卒業間近です。4年間の教育の後、私は人生の海への最初の一步の準備をしているようです。卒業最後の年、学生ではなく徴兵されて国の息子となりました。徴兵された後、学校を中退することを拒否しました。仕事もさることながら、諦めずにオンラインで勉強して卒業…。昨年は同級生と一緒に、友達や先生、学校とたくさんの思い出を作ることができました。

ИНЭЭН БАЯССАН, ДОГДЛОН ГЭГЭЛЗСЭН, ДУРЛАН ХАЙРЛАСАН, ХИЙЖ БҮТЭЭСЭН ТИЙМ САЙХАН ОН ЖИЛҮҮД

Оюутан насны минь эхний намар ямархан удаан өнгөрч байсан гээч... Таньж мэдэхгүй газар олон танихгүй хүмүүсийн дунд яажшуухан хөглөж байснаа дурсахаар өөрийгөө өхөөрдөн харж инээмсэглэн суудаг юм. Навчис шарлан унах дөхөхөд нь нулимс цийлэгнэн уйлах дөхөж, хатуу ширүүн үг, болоод магтаал урамшууллыг харамгүй сонссон тэр л намар миний амьдралыг шинээр эхлүүлсэн юм. Амьдралын минь анхны алхам оюутан насны эхний намар байсан. Үеийн олон нөхдийн дунд, ийм мундаг багш нараасаа их эрдмээс нь өвлөн авахаар ирсэн шавилхан хүү би одоо төгсөх болжээ. Энэ л дөрвөн намар, дөрвөн өвөл, дөрвөн хаврыг ардаа үлдээж. Энэ л он жилүүд дурсамж дурьдатгал дүүрэн. Тийм л яруухан дурсамжийн тухай Тэгтлээ их үгүйлэх нөхөрлөлийн тухай Тоолоод ирдэггүй хоногийн тухай Хүлээгээд сөхөрдөггүй итгэлийн тухай Бүтэлтэй дурлалын тухай дурсмаар..

Өчигдөр өнөөдрөөр, өнөөдөр маргаашаар солигддог цаг хугацааны урсгал ирээдүйг бидэнд авчирдаг. Оюутан цагийн орлуулашгүй тэр дурсамжуудын талаар инээн баяссан, догдлон гэгэлзсэн, дурлан хайрласан, хийж бүтээсэн тийм сайхан он жилүүд. Гал шиг дүрэлзэх идэр залуусын тэнхээ. Та бүхэн минь оюутан насны гэрэлт өдрүүд, гэгээн дурсамжуудаараа хөглөгдөж амьдраарай...

Үргэлж тусалж дэмжиж байсан Соёл Эрдэм дээд сургуулийн нийт хамт олон, эрдэмтэн багш нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

学生時代の初めの秋は本当に長く感じていた。知らない大学と人々を見て、緊張したり、困ったりしていたことを思い出すと、いつも懐かしく微笑む。 葉が黄色くなりかけた頃、涙が出そうになったり、 厳しいことばと励ましのことばを聞いた、その秋は私の人生を変えた。その秋は私の人生の最初のステップとなったのだ。同級生と一緒に、立派な先生方にいろいろな知識を習いにきた私は、卒業を迎えている。4回の秋、4回の冬、および4回の春が経って、思い出でいっぱいである。

そんな懐かしい思い出について 寂しくなる友情について 無限の日々について ずっと待っても諦めない信頼について 失敗した恋愛について思い出したい。 昨日が今日に、今日が明日に変わる時の流れは、私たちに未来をもたらす。学生時代のかけがえのない思い出について笑ったり、興奮したり、愛したり、成功したりした素晴らしい年。若者たちのエネルギーは常に火のように燃える。みなさん学生時代の明るい日々、明るい思い出を忘れないで幸せに生きてください。 最後に、いつもお世話になっていたモンゴル文化教育大学の教職員に心から感謝の気持ちを申し上げます。



4В анги Г.Ган-Эрдэнэ
日本語学科4年生 ガンエルデネ

私の名前はガンエルデネです。この学校に入学して、日本語と日本文化を学べてよかったです。日本語がまったくわからない私に、「あ」から「ん」まで教えてくださった日本語学科の先生方には、感謝してもしきれません。 少し前までは学校の門をくぐると学生と呼ばれていましたが、今度は卒業して人生の海に出る時が来ました。学生時代の一番の思い出は、クラスメートとの楽しい思い出がたくさんできたことです。 この4年間はとても楽しく、あつという間だったと思います。コロナウィルスの影響でオンラインでの活動は2年ほど続きましたが、ここ数年は本当に楽しい思い出でいっぱいだったと思います。 日本語学科の先生方、他学科の先生方、クラスメートの皆さん、本当にありがとうございました。

КИТОГОИЙН ИХ СУРГУУЛИЙН СУДЛААЧ ОЮУТНЫ НЭГ ЖИЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ДҮҮРГЭСЭН

Хэдийгээр одоогийн ангитайгаа хамт өнгөрүүлсэн адал явдлаар дүүрэн 4 жил байхгүй ч Соёл-Эрдэм Дээд Сургуульд элсэн орсноос хойш 3 жилийн хугацаанд бүтээсэн олон сайхан дурсамжууд байдаг. 3 дугаар ангидаа 1 жилийн хугацаанд алсын япон орны Киотогийн их сургуульд суралцаад ирсэн ба энэ бүхэн маань бүгд ачлалт багш хамт олны минь ач гэж би бодож явдаг. Япон хэл соёлыг сонирхож эхлээд одоо япон хэлний орчуулагч болохоор зорин нэг л мэдэхэд төгсөх ангидаа суралцаж байна. Гэсэн ч би насан туршийн найз нөхөд болон насан туршдаа санаж явах дурсамжуудыг бүтээж чадсан. 3 дугаар ангид байхдаа би Киотогийн их сургуулийн судлаач оюутны нэг жилийн хөтөлбөрийг дүүргэн эх орондоо буцаж ирсэн. Энэхүү хөтөлбөрт оролцохын тулд би Соёл-Эрдэм Дээд сургуулиас жилийн чөлөө авсан тул 2022 онд эргээд ирэхэд ижилдэн дассан нөхөд минь аль хэдийнээ төгсөж би таньж мэдэхгүй хүүхдүүдтэй нэг анги болон суралцсан. Гайхмаар нь нэг анги болоод ердөө 2 сар л болж байхад аль хэдийнээ хамтдаа адал явдалт 4 жилийг туулсан мэт л санагдах болсон юм. Ахлах сургуулиа төгссөнөөс хойш оюутны амьдралыг мэдэрч чадаагүй байсан надад Соёл-Эрдэм Дээд Сургуулийн багш ажилтан болон хайр татам оюутнууд дурсамж дүүрэн гайхалтай сайхан 4 жилийг бүтээж өгсөнд маш их баяртай байна.

私には今のクラスのみならず一緒に過ごした4年間はないですが、この大学で過ごした大切な3年間の思い出はあります。残りの1年を日本の京都大学で日研究生として留学しましたが、そこまで行けたのもモンゴル文化教育大学の先生方のおかげでした。日本と日本語のこと興味を持ち始め、日・モ翻訳通訳者になることを目指してから4年間はあつという間に過ぎてしまいました。ですが、私は一生の友達と一生残る思い出を作ることができました。 3年生の時、私は京都大学へ日研究生として日本の文化や日本という国を体験できる1年のプログラムに参加することができました。しかし、日本へ行くためにモンゴル文化教育大学から1年の休学を取らなければならなかったため、2022年に戻った時は見ず知らぬ人たちと一つのクラスとなりました。新しいクラスに入って、たった2か月しかたっていないのに、なぜか一緒に4年間を過ごしたように感じがします。高校卒業して以来、大学生活を味わうことができませんでしたが、この大学とこの大学に通っている学生たちや先生方のおかげで忘れられない大学生活を過ごすことができました。心から感謝いたします。

ОЮУТНЫ ДУРСАМЖ

Соёл Эрдэм дээд сургуульд элсэн орж байсан үе саяхан мэт санагдаж байгаа хэдий ч нэгэнт төгсөх цаг иржээ. Оюутан насны он жилүүд удаан мэт боловч эргээд бодоход үнэхээр хурдан өнгөрчээ. Энэ хугацаанд олон сайхан найз нөхөдтэй болж, сургуулиас зохион байгуулсан олон төрлийн тэмцээн уралдаанд орж өөрийгөө сорьж, өөрийгөө шинээр нээж чадсан. Эзэмшсэн эрдэм мэдлэг, амьдралын туршлага, найз нөхөд минь ирээдүйн амьдралын минь салшгүй нэг хэсэг болон үлдэж байгаад баяртай байна. 1-р курсэд байхдаа сургуулийн “Соёлын баяр”-т оролцохын тулд хичээлийн дараа орой болтол бэлдэж, амжилттай оролцож байсан үеэ санахад сайхан байна. Мөн явган аялалд явж байсан үе ч үнэхээр хөгжилтэй байсан. Ингээд найз нөхөд, багш нар, оюутан насаа орхино гэхээр сэтгэлд жаахан гуниг хурж байна. Оюутан нас минь амьдралын минь хамгийн сайхан мөчүүдийн нэг болж үүрд үлдэнэ. Үргэлж зааж сургаж, тусалж дэмжиж байсан Соёл Эрдэм дээд сургуулийнхаа нийт багш ажилтан, ангийн найзууддаа чин сэтгэлийн талархал илэрхийье. Маш их баярлалаа. Дахиж ирэхгүй намар Ахиад олдохгүй оюутан нас минь баяртай.

モンゴル文化教育大学に入学した時期が最近のように思われるが、すでに卒業近づいてきた。学生時代はとても長く感じられたが、本当に早く過ぎ去った。たくさんの素晴らしい友達ができ、大学の様々なイベントに参加して、なんでも挑戦するようにしていた。習得した知識、体験したこと、素晴らしい友達、すべてこれからの人私の生に欠かすことができないものになっているのでとても嬉しい。 1年生のときに、文教祭に参加するために放課後に遅くまで練習していたのは懐かしい。また、同級生と一緒に遠足に行った時も楽しかった。先生方と同級生と学生時代と別れると思ったら悲しい。学生時代は私の人生での素晴らしい時期の一つとして一生忘れられない。 いつも丁寧に心から教えたり、応援したりしていただいた、モンゴル文化教育大学の職員と先生方と同級生に深く感謝しています。どうもありがとうございました。皆さんの夢が叶うように。 二度と来ない秋 二度と見つからない貴重な学生時代 さようなら。



4Е анги Х.Билгүүн
コンピュータープログラム学科 4年生 ビルグーン



ЯПОНД СУРАЛЦАНГАА АЯЛЖ, МӨРӨӨДЛӨӨ БАГА БАГААР БИЕЛҮҮЛСЭЭР БАЙНА

Хамаатны эгч маань Соёл Эрдэм дээд сургуулийн япон орон судлалын ангид элсэн суралцаад 2-р курсээсээ оюутан солилцоогоор Япон явсан тул би Япон орныг сонирхож 2016 онд япон хэл орчуулагчийн ангид элсэн орсон юм. Хичээлийн эхний өдөр япон үсэг заагаад шууд шалгалт авахад нь чадахгүй байх гэж айж байсан боловч сонирхолтой аргаар заасны ачаар хагасыг нь тогтоосон байсан. Ингээд япон хэл сурах хүсэл минь улам их нэмэгдсэн юм. Манай ангид япон хэл заасан Бүрэнчимэг багш маань хичээлээ хөгжилтэй арга барилаар зааж түүнчлэн япон орны тухай, Япон дахь оюутан насныхаа дурсамжийн тухай ярихадих сайхан санагддаг байсан. Бас Мөнхтуул багш маань ханзыг хялбар цээжлэх аргыг зааж шинэ үг ашиглан өгүүлбэр зохиолгодог байсан тул үг хурдан тогтоож, үгийн сангаа арвижуулж чадсан.

Багаасаа аниме үзэх дуртай байсан сонирхол, үзэл бодол ижил хамгийн дотны хоёр болсондоо үнэхээр их баяртай байдаг. Хамтдаа номын санд өдөр нь хичээлээ бэлдэж хоорондоо ярилцаж шинэ үгийн тоглоом тоглож цагийг үр бүтээлтэй өнгөрөөдөг байсан. Мөн чөлөөт цагтаа сургуулийнхаа спортын тэмцээн, соёлын өдөрлөгт бэлдэж байсан оюутан насны минь цаг мөч бүхэн үнэ цэнэтэй санагдаж байна.

Түүнийхээ ачаар хамтдаа Японд ирж суралцангаа Япон улсын олон алдартай газраар аялж, уламжлал болсон дэлхийд алдартай хоолнуудыг нь идэж Монголд байхдаа мөрөөддөг байсан зүйлсээ бага багаар биелүүлж байна. Сургуулийнхаа япон багш нарын ачаар японы хүний талаар мэдлэг болсон нь Японд ирэхэд их тус болсон. Япон улс чанга хууль дүрэмтэй, өндөр соёлтой, хүмүүс нь эелдэг найрсаг хэдий ч мэдээж сайны хажуугаар саар олон зүйл бий.

Соёл Эрдэм дээд сургуульд элсэн суралцсанаар япон хэлтэй болоод зогсохгүй япон соёл, ахуй, дүрэм журам гэх мэт олон зүйлийг суралцдаг. Түүнчлэн төгсөөд Япон улсад мэргэжлээ дээшлүүлэн суралцах, гадаадын олон найз нөхөдтэй болох олон сайхан боломжууд бий. Ийм үнэтэй боломж олгосон сургуулийнхаа нийт хамт олонд чин сэтгэлээсээ талархаж байна.

私の親戚がモンゴル文化教育大学日本事情学科に入学して、2年生から交換留学で日本に行ってから今日まで日本で勉強しながら働いていることがきっかけで、私は2016年に日本語通訳翻訳学科に入学しました。

入学してから、日本語のひらがなの授業の後ですぐに試験をとることにすごくびっくりしました。試験を受けて、半分くらいできたので嬉しかったです。先生方が興味深い色々な方法で教えてくれたので、進むのが速かったのですが、よく覚えられました。文法のブレンチメグ先生が楽しく教えながら、日本や日本の学生生活について、いつも面白い話をしてくださいました。そして、ムンフトール先生が漢字の覚え方と新しい言葉を使った例文を教えてくださいましたので、たくさんの言葉を速く覚えることができました。

私は子どものときからアニメを見るのが好きでしたが、日本語がわからないので内容がよくわかりませんでした。しかし大学に入学してから趣味が同じ友達ができうれしかったです。図書館で勉強しながら話したりしました。勉強以外の時間でスポーツ大会や文教祭にも参加して学生生活を楽しく過ごしました。モンゴル文化教育大学に入学して、友達ができて、日本の生活やルールも良く理解しました。

モンゴル文化教育大学に入学したら、卒業までに日本語のほかに日本のルールや文化もよく理解することができます。その上、卒業後、日本で就職したり、日本の有名大学に留学するチャンスもあります。そんなたくさんの機会を与えてくれた先生方に感謝申し上げます。

ЯПОН УЛСАД ДАДЛАГАЖИГЧААР ЯВСАН



4В анги Э.Дуламноров
日本語学科4年生ドラマノロブ

Мэдээж бид өөр орны хүмүүс учраас соёлын ялгаа, хэл ойлголцоход бэрхшээл гарч байсан ч найзууд болж чадсан юм. Хэдийгээр богинохон 5 хоног байсан ч мартагдашгүй сайхан үе байсан. Мөн оюутан байх хугацаандаа Япон улсад дадлагажигчаар явах боломж олдсонд баяртай байна. Тус хөтөлбөрөөр өөрийн япон хэлний мэдлэгийг дээшлүүлэн, японы бизнес, үйлчилгээний соёлыг илүү ойроос таньж мэдэх нь оюутан үеийн хамгийн үр өгөөжтэй хичээлүүдийн нэг болно гэж бодож байна.

Энэ 4 жилийн хугацаанд надад зааж сургаж, олон талаар өөрийгөө хөгжүүлэх боломж олгосон багш нар, ангийн найзууддаа маш их талархаж байна. Та бүхэндээ амжилт хүсье.

振り返ってみると、学生時代の4年間はあっという間に過ぎていきました。モンゴル文化教育大学の最も興味深いイベントは、間違いなく文教祭です。入学したばかりで日本語をまだ覚えていないのに日本語で歌を歌うのが難しかったのですが、優勝しました。2020年はコロナ禍で文教祭が中止になりましたが、去年、3年生のときに演劇とスピーチコンテストに参加することになったのは最も思い出に残っています。

3年生の夏休み、ホームステイの日本人を受け入れることになって、日本人と交流する機会がありました。そして日本人の友達と一緒にウランバートルの街を観光して、ネイルサロンにも行きました。いろいろなことについて話して、お互いの国の文化習慣などについて教えたのは本当に面白いでした。私たちには文化や言語の問題もありましたが、友達になりました。5日間という短い期間でしたが、思い出深いものとなりました。

また、学生時代にインターンシップとして日本に行く機会があったことをうれしく思います。このプログラムを通じて、日本語能力を向上させ、日本のビジネスやサービス文化をより深く知ることは、学生生活の最大の目的の1つだと思います。この4年間、自分自身を成長させる機会を与えて、教えてくれた先生方とクラスメートに本当に感謝しています。

学生の思い出 ОЮУТАН НАСНЫ ДУРСАМЖ



4В анги Ө.Содбаяр
日本語学科4年生ソドバヤル

学生時代は間違いなく人生で一番楽しい時期であり、思い出と挑戦に満ちていますが、あっという間に過ぎてしまいました。学生時代のかげがえのない思い出を楽しんで、興奮し、また恋に落ちた時代でした。この4年間でこれからの生きる道を見つけた。これから身に付けた知識と先生方を誇りに生きていきます。

いつも親切にサポートしたり、丁寧に教えてくれたりしていたモンゴル文化教育大学の教職員の皆さん、お互いに手伝ってきたクラスメートたちに感謝しています。ご活躍お祈りいたします。



4В анги Н.Анужин
日本語学科4年生 アヌジン

欠席した講義の埋め合わせ、準備不足のゼミ修了、恋に落ちた翌日の悲しみ... 私たちは、その興奮と洞察の年を後にしています。わくわくする人生の騒がしい瞬間に一緒にいてくれた先生たち、そして特別な出会いに満ちた美しい思い出に胸がいっぱいです。

はじめの一步を踏み出した若者たち、命の大海原を共に歩こう... 私の同世代の友人の中で、私は偉大な教師たちの偉大な知識を受け継ぐようになった女子学生です。これにより、4回の秋、4回の冬、および4回の春が残ります。この数年は思い出でいっぱいです。

昨日が今日に、今日が明日に変わる時の流れは、私たちに未来をもたらします。

学生時代のかげがえのない思い出についての笑い、興奮、愛、そして達成の素晴らしい年。

ОЛОН ЗҮЙЛИЙГ ХАМТДАА ХИЙЖ БҮТЭЭСЭН АНГИЙН НАЙЗУУДДАА МАШ ИХ БАЯРЛАЛАА

Гантай зуны элсэн цөл шиг
Галтай нас хайраар ангасан
Очтой асах хуурай мод шиг
Омгolon зүрх хайраар бадарсан
Оюутан байх сайхаан ... гэдэг шиг хүний амьдралын хамгийн сайхан дурсамжтай, бүтээлч нас бол энэ цаг үе юм. Жигүүрээ ургаж гүйцэхээр өнгөт энэ орчлонгоос өөрийн гэсэн өнгө төрх, буух нуураа олохоор нисэн одоход бэлтгэж буй талбар бол оюутан цагийн минь анги танхим, дурсамж дүүрэн оюутны өргөө минь юм даа. Энэ дөрвөн жилийн хугацаа маш хурдан өнгөрлөө. Олон зүйлийг хамтдаа хийж бүтээсэн ангийн найзууддаа маш их баярлалаа. Мөн бидэнд зааж сургасан сайхан сэтгэлт багш нартаа баярлалаа. Үеийн олон нөхдийн хамт эрдэмтэн багш нарынхаа их эрдмээс өвлөн авахаар ирсэн шавилхан охин би одоо төгсөх болжээ. Энэ л дөрвөн намар, дөрвөн өвөл, дөрвөн хаврыг ардаа үдлээ.

Энэ л он жилүүд дурсамж дүүрэн, Тийм л яруухан дурсамжийн тухай Тэгтлээ их үгүйлэх нөхөрлөлийн тухай Тоолоод ирдэггүй хоногийн тухай Хүлээгээд сөхөрдөггүй итгэлийн тухай Бүтэлтэй бүтэлгүй дурлалын тухай дурсмаар...

Өчигдөр өнөөдрөөр, өнөөдөр маргаашаар солигддог цаг хугацааны урсгал ирээдүйг бидэнд авчирдаг. Тасалсан лекцээ нөхөх гэж, дутуу бэлдсэн семинараа гүйцээх гэж, дурласныхаа маргааш гуниглах гэж, хайрласныхаа дараа гэгэлзэх гэж... уяран догдолсон, ухааран бодсон тэр он жилүүдийг бид ардаа орхиж байна. Оргилуун амьдралын минь шуугиант мөчүүдэд минь хамт л байсан багш нараа, онцгой нэгэн учрулуудаар дүүрэн энэ л сайхан дурсамжууддаа хоргодоод байх юм сэтгэл минь...

乾いた夏の砂漠のように
燃える時代は愛で開かれた
火花を散らした乾いた木のように
心は愛に満ちていた
学生時代はよかった... この時期は、人生で最も記憶に残り、創造的な時代です。学生時代の教室、思い出の詰まった校舎は、自分の色を求めて飛び立ち、翼に追いつくためにこの色の宇宙から着陸する湖です。この4年間はあっという間でした。一緒にいろいろなことをしてくれた同級生には本当に感謝しています。また、私たちに教えてくれた素晴らしい先生方に感謝します。同世代の同世代の中でも、私はそんな優秀な先生方の素晴らしい知識を受け継ぐことになった女子学生です。この4つの秋、4つの冬、4つの春です。つまり、ここ数年は思い出でいっぱいです、そんな短い思い出について、とても恋しい友情について、戻って来ない日に..。大学生時代の4年間は、夢のような世界であり、いつまでも心の中に残っていることだと思います。この数年間は思い出がたくさん詰まっていて、そんな短い思い出についてとても懐かしくなる友情について数えても戻ってこない日々についてたとえ待ってもあきらめない信頼について思い出したい。

成功した恋と失敗した恋を思い出したい。昨日を今日、今日を明日と置き換える時の流れが、私たちに未来をもたらします。私たちは、欠席した授業のノートを書き留め、準備不足の発表を終わらせ、恋に落ちた翌日に悲しみ、恋に落ちて混乱した日々を送っています。活発な人生の騒がしい期間と一緒にいた同級生と先生方に感謝を申し上げます。本当に特別な出会いに満ちた美しい思い出に心を奪われます。

АМЬДРАЛЫН МИНЬ ЖАРГАЛТАЙ МӨЧҮҮДИЙН НЭГ

Ахлах сургуулиа төгсөөд их сургуульд оюутан болж орсон нь миний амьдралын жаргалтай мөчүүдийн нэг байсан. Оюутан байх 4 жилийн хугацаанд олон шинэ зүйлийг мэдэж, мэдлэг чадвар эзэмшсэндээ баяртай байна. Оюутан байх үе маань жаргалтай ч зөөлөн гунигтай нэг тийм сэтгэл хөдөлгөм үе байсан. Энэ үед юм болгон сонирхолтой, хөгжилтэй байсан төдийгүй амьдралын ухаанаас олон зүйлийг суралцаж авсан.

Ийм сайхан дурсамж, хэзээ ч мартагдашгүй сэтгэгдлийг хамт бүтээлсэн Соёл Эрдэм дээд сургуулийн багш нар болон оюутан найз нөхөддөө маш их баярлалаа. Та бүхэн цаашдаа янз бүрийн саад бэрхшээл тулгарсан ч няцаж шантралгүйгээр даван туулж, зорилгодоо заавал хүрээрэй.

高校を卒業して大学に入学したことは私の人生の中で一番幸せな日々でした。大学生時代の4年間で色々な知識を得られたことに対して感謝しています。私にとって大学生であることは、とても楽しいことでした。楽しいだけでなく、たくさんの学びもありました。

この記憶と感動と一緒に作った大学の先生方と学生の皆さん、ありがとうございました。皆さん社会人になっていろいろな問題が起こってもあきらめないで一生懸命に頑張ってください。



4Е О.Намуун
コンピュータープログラム学科
4年生 ナムーン

